

**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.11.22

Орхон аймаг

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах нэгж	Гүйцэтгэлийн үзүүлэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг Орхон аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах, боломжтой бүх хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх</p>	<p>-Мэдээлэл технологийн ажилтан -хэлтсийн нийт албан хаагчид</p>	<p>АТГ-аас болон УБЕГ-аас гаргаж буй олон нийтэд зориулсан сурталчилгааны материалыг өөрийн пэйж хуудас болон АЗДТГ-ын info сайтад 9 удаа байршуулан олон нийтэд хүргэсэн. Тус хэлтсийн үйл ажиллагаа, албан хаагчтай холбоотой авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг байгууллагын 70358989 утсаар болон АТГ-ын 110 болон 1800-1969 дугаартай утас, www.iaas.mn вэб сайт,contact@iaas.mn цахим хаягаар ирүүлэхийг өөрийн Орхон аймгийн улсын бүртгэл цахим хаяг болон байгууллагын ил тодын самбарт байршуулсан.</p>
		<p>1.2.АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг Орхон аймаг болон хэлтсийн хэмжээнд зохион байгуулах</p>	<p>Хэлтсийн дарга Тасгийн дарга нар</p>	<p>Хэлтсийн албан хаагчдад авлигахүнд сурталаас ангид байх талаарх 2 удаагийн сургалтыг зохион байгуулж , мэдээ мэдээллээр ханган ажиллалаа. Албан хаагчдын өрөөний хаалга, үйлчилгээний танхимын цонх бүрт авлигаас урьдчилан сэргийлэх наалт бүхий тэмдэглэгээг иргэдэд</p>

				харагдахуйц байдлаар байршуулснаар авлигаасангид байх, урьдчилан сэргийлэх нэг нөхцлийг бүрдүүлсэн. Мөн авлигын эсрэг хуулиар мэдээлэл хийж байгууллагын фейсбүүк хаягт “Авлигын эсрэг хамтдаа нэгдье” сэдэвт контентийг байршуулж иргэдэд мэдээллийг хүргэсэн.
		1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 100” мэдээллийн самбар ажиллуулах.		Байгууллагын үйл ажиллагаа мэдээлэл сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 100” ил тодын самбарт авлигын эсрэг хийгдэж буй үйл ажиллагааны 5 удаагийн мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ил тод байдлыг ханган ажиллаж байна.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад эрсдэлт бүлгийн албан хаагчдаа хамруулсан байх	-Хэлтсийн дарга	АТГ-аас авлигын эсрэг сургалт зохион байгуулагдаагүй.
		2.2. Хэлтсийн тасаг бүр санаачилга гарган авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэд, хүүхэд залууст үр дүнтэй, шинэлэг арга хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх	-Тасгийн дарга нар -улсын бүртгэгч нар	Хэлтсийн тасаг бүрээс санаачлан авлигын эсрэг сургалтыг зохион байгуулах хуваарийн дагуу эд хөрөнгий тасгаас “Авлига-Аз жаргалын эсрэг гэмт хэрэг” сэдэвт 1 удаа сургалт явуулсан.
3	Авлигатай тэмцэх	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн	-Хэлтсийн	Тайлант хугацаанд Авлигатай

	газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	зөвлөмж, 3.2.Мөрдөгчийн мэдэгдэл, 3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	дарга -Хяналтын улсын байцаагч	тэмцэх газраас зөвлөмж, мэдэгдэл, зөрчил арилгуулах талаар ямар нэгэн албан бичиг ирүүлээгүй байна.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдсэн байдал 4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Хэлтсийн дарга	Байгууллагаараа “Авлигын эсрэг нэгдье” аянд нэгдэн ажиллаж байна. Хэлтсийн албан хаагчдаас авлигаас ангид байх баталгааг гаргуулан ажиллаж байна.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах явцад хяналтыг сайжруулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, ажлын байрыг сэлгүүлэн ажиллуулах/	-Хэлтсийн дарга -Хяналтын улсын байцаагч -Тасгийн дарга нар	- Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр үйлчилгээг цахимжуулах, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд цахимаар бүртгэл хийлгэх бүртгэлийн тоо нэмэгдсэнээр танхимаар ирж үйлчлүүлэх иргэний тоо буурч иргэн гэрээсээ үйлчилгээ авах нөхцөл боломж бүрдсэн. Цахим бүртгэлээр бүртгэл авсан иргэний бүртгэлийн цахимжуулах явцад бүртгэл бүр үнэн зөв цахимжсанд хяналт тавин ажиллаж байна.
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод,	6.1. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан арга хэмжээг заасан		Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан “Төсвийн

	<p>нээлттэй сайжруулах байдлыг</p>	<p>хугацаанд цахим хуудаст байршуулж, иргэд олон нийт танилцах боломжоор хангах;</p> <p>6.2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан арга хэмжээг заасан хугацаанд цахим хуудаст байршуулж, иргэд олон нийт танилцах боломжоор хангах;</p> <p>6.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;</p> <p>6.4. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах.</p>	<p>-Нягтлан бодогч</p> <p>-Мэдээлэл технологийн ажилтан</p>	<p>орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх”гэсний дагуу тайлант хугацааны нийт 171 мэдээ, мэдээллээс 148 мэдээ мэдээллийг цахим хуудсандаа байршуулж иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангаж ажилласан.</p>
--	------------------------------------	--	---	--